

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ 2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр, Лхагва гараг

|                                   |         |
|-----------------------------------|---------|
| Хуралдааны тэмдэглэлийн агуулга   | 1       |
| Хуралдааны төвч тэмдэглэл:        | 2 - 30  |
| Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: | 31 - 69 |

|    |  |
|----|--|
| 1. | Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын З гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 31 - 50                            |
| 2. | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын З гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 50 - 62 |
| 3. | Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын З гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 62 - 68           |
| 4. | “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 68 - 69                        |

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 04 дүгээр сарын 24-ний өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хурэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 30 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, С.Бямбацогт, Г.Ганболд, Ц.Мөнх-Оргил,  
Ж.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Ж.Батсуурь, Ё.Баатарбилэг, Т.Доржханд;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Жаргалмаа.

**Нэг. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын З гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Баярмаа, Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, А.Наранцэцэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.**

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**Н.Энхболд:** 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.5, 4.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.5.Улсын Их Хурал тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас, шагналтай байна.

4.6. Улсын Их Хурлын оноосон нэртэй адил утга, агуулгатай нэр, нэрийн товчлолыг зөвшөөрөлгүй ашиглахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.8 дахь хэсэг нэмэх:

“4.8. Улсын Их Хурал өөрийн стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

3. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “хэлэлцэх нийт хугацааг тогтоох” гэснийг “хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр тогтоох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 14, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 14, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

4. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.25 дахь хэсгийн “үл хүндэтгэсэн үйлдэл гэж үзнэ.” гэснийг “үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 22, 23, 24, 25, 26 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 22, 23, 24, 25, 26 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**5.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.5.4 дэх заалтын “бүрэн эрхтэй холбогдсон асуудлыг” гэсний өмнө “халдашгүй байдал,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**6.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.12 дахь хэсэг нэмэх:

“27.12.Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн saatlyin улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.12 дахь хэсэг нэмэх:

“27.12.Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4

Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**7.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “хянан шалгагч томилох, бичиг баримтад дүн шинжилгээ хийх зэрэг” гэснийг “хянан шалгагч, шинжээч томилох, бичиг баримтад дүн шинжилгээ хийх, гэрчээс мэдүүлэг авах зэрэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**8.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.5.3 дахь заалтын “яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар” гэснийг “яллагдагчийг шүүхэд шилжүүлснээс хойш хоёр жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**9.**Ажлын хэсгийн гаргасан, 28 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 28.6, 28.11 дэх хэсэг нэмэх:

“28.6.Тухайн ээлжит чуулганы хугацаанд хоёр хүртэл хянан шалгах түр хороо ажиллаж байгаа бол Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хянан шалгах түр хороо байгуулах саналыг дараагийн ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэнэ.

28.11.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хянан шалгах түр хорооны дарга, гишүүнээр ажиллахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**10.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.4, 29.13 дахь хэсгийн “12” гэснийг “10” гэж, мөн зүйлийн 29.4, 29.9 дэх хэсгийн “12-оос” гэснийг “10-аас” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 29 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 29.3-т “бүлэг даргаа гишүүдийн олонхын саналаар сонгож бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрийн жагсаалтыг бүлгийн дарга бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлгийн эрх, үүрэг хэрэгжиж эхэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн saatlyin улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 29.3-т “бүлэг даргаа гишүүдийн олонхын саналаар сонгож бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрийн жагсаалтыг бүлгийн дарга бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлгийн эрх, үүрэг хэрэгжиж эхэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 30 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 30 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Төслийн 31 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 32.1-д “бүлэг” гэсний дараа “бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаандаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж тайлбар хийв.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

-Төслийн 32, 33, 34, 35, 36, 37 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 32, 33, 34, 35, 36, 37 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**Н.Энхболд:** 11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|   |    |
|---|----|
| Зөвшөөрсөн:                               | 5  |
| Татгалзсан:                               | 5  |
| Бүгд:                                     | 10 |
| 50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. |    |

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн “дэмжсэн” санал техникийн saatlyin улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                                    | 6  |
| Татгалзсан:                                    | 4  |
| Бүгд:  | 10 |
| 60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. |    |

**Н.Энхболд:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

-Төслийн 39, 40, 41, 42, 43 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 39, 40, 41, 42, 43 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Төслийн 44 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлд 44.1.16 дахь заалт нэмэх:

“44.1.16.гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд иргэд, сонгогчдод тайлангаас бусад эд, зүйлс тараах, аливаа хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлдэл, үйл ажиллагааг хийхгүй байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар, С.Одонтуяа нар тайлбар хийв.

|   |    |
|---|----|
| Зөвшөөрсөн:                               | 2  |
| Татгалзсан:                               | 8  |
| Бүгд:                                     | 10 |
| 20.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. |    |

Дээрх санал дээр Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа цөөнх болов.

-Төслийн 45 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 45 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Н.Энхболд:** 12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.5.4 дахь заалтын “Хууль тогтоомжийн тухай хуульд” гэсний өмнө “энэ хуулийн 36 дугаар зүйл,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай хоёр дахь өгүүлбэр нэмэх:

“Энэ журам нь Төрийн албаны тухай хуулийн 54.2, 55.2-т заасан журмаар зохицуулах харилцаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

-Төслийн 47, 48, 49 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 47, 48, 49 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**Н.Энхболд:** 14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|   |    |
|---|----|
| Зөвшөөрсөн:                               | 5  |
| Татгалзсан:                               | 5  |
| Бүгд:                                     | 10 |
| 50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. |    |

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн saatlyin улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                                    | 6  |
| Татгалзсан:                                    | 4  |
| Бүгд:  | 10 |
| 60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. |    |

**Н.Энхболд:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

-Төслийн 51, 52, 53 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 51, 52, 53 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

#### Найруулгын санал:

**Н.Энхболд:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.9 дэх хэсгийн “ба” гэсний дараа “түүнээс” гэж, 24 дүгээр зүйлийн 24.9, 24.10 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийн “зардлыг” гэсний өмнө “үйл ажиллагааны” гэж тус тус нэмж, 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн “зардлыг санхүүжүүлнэ.” гэснийг “үйл ажиллагааны зардлыг зориулалтын дагуу зарцуулна.” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь

хэсгийн “зааснаас” гэснийг “заасны дагуу томилогдоноос” гэж, 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийн “хууль тогтоомжийн” гэснийг “хуулийн” гэж, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсгийн “Энэ зүйлд” гэснийг “Энэ хуулийн 36 дугаар зүйлд” гэж, 44 дүгээр зүйлийн 44.4.1.6 дахь заалтын “кампанит ажилд” гэснийг “сурталчилгаанд” гэж, 46 дугаар зүйлийн 46.5.17 дахь заалтын “мэдээллийн сан бүрдүүлж гишүүдэд үйлчлэх” гэснийг “мэдээллийн сан бүрдүүлэх” гэж тус тус өөрчлөх.

**2. Төслийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн “тогтоох асуудлыг” гэснийг хасах.**

**3. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын болон тэдгээрт авсан эшлэлийн дугаарлалтыг өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх гэсэн найруулгын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.**

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Монгол Улсын Их Хурлын тогтооолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

-Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

## **НЭГ.МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**Н.Энхболд:** 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “тус тус өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24<sup>6</sup>.2-т” гэснийг “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 52.2-т”” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|   |    |
|---|----|
| Зөвшөөрсөн:                               | 5  |
| Татгалзсан:                               | 5  |
| Бүгд:                                     | 10 |
| 50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. |    |

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн “дэмжсэн” санал техникийн saatlyin улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                                    | 6  |
| Татгалзсан:                                    | 4  |
| Бүгд:  | 10 |
| 60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. |    |

**Н..Энхболд:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “тус тус өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24<sup>6</sup>.2-т” гэснийг “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 52.2-т”” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

-Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

### **Хоёр.ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**Н.Энхболд:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

-Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

### **Гурав.ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

-Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

**Н.Энхболд:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасаж, төслийн 3 дугаар зүйлийн дугаарыг “2 дугаар зүйл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 6  |
| Татгалзсан: | 4  |
| Бүгд:       | 10 |

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтооолын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

### **Дөрөв.“ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

**Н.Энхболд:** 1.Ажлын хэсгийн гаргасан, “Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2008 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 28 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтооолын төслийн 1 дэх заалтын “-ийг энэ тогтооолын” гэснийг “гэсний “Улсын Их Хурлын гишүүний тойрогт ажиллах унааны лимит” гэж өөрчлөн энэ тогтооолын” гэж, төслийн 2 дахь заалтын “28 дугаар тогтооолын 1 дэх заалтын 1, 2, 3, 4, 5 дахь” гэснийг “28 дугаар тогтооолын 1 дэх заалтын 1, 2, 3, 4 дэх” гэж тус тус өөрчилж, уг тогтооолын 2 дугаар хавсралтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

#### **Найруулгын санал:**

**Н.Энхболд:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Улсын Их Хурлын гишүүний төсөв зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам”-ын 1.2.4, 2.2-т “сонгогдсон тойрогтоо” гэснийг “тойрогт” гэж тус тус өөрчилж, мөн журмын 1.2.5-д “гэрээний үндсэн дээр ажиллуулах” гэснийг хасах.

2.Зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн заалт, хавсралт болон тэдгээрт авсан эшлэлийн дугаарлалтыг өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

-“Тогтооولد өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Тогтооولد өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 15 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Баярмаа, Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, А.Наранцэцэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.**

-Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**Н.Энхболд:** 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 6, 7, 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 6, 7, 8 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “хэлэлцэх хугацааг” гэсний дараа “хэлэлцүүлгийн үе шат бүрээр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“9.7.Гишүүн хуралдаанд байр сууриа илэрхийлж үг хэлэх /цаашид “үг хэлэх” гэх/ хугацаа 4 минутаас илүүгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Улсын Их Хурлын гишүүн тойротг ажиллаж иргэдийн гаргасан санал хүсэлт, гомдлын талаар 4 минутаас 2-оос доошгүй удаа нэгдсэн хуралдаанд үг хэлж болох ба Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэлээ бичиж ирүүлнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 7  
Бүгд: 10  
30.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дээрх санал дээр Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж цөөнх болов.

-Төслийн 10, 11, 12, 13, 14, 15, 16 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 10, 11, 12, 13, 14, 15, 16 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**Н.Энхболд:** 4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.14 дэх хэсгийн “программ, эсхүл санал хураах хуудсаар явуулна.” гэснийг “программ ашиглан явуулна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн saatlyin улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн “дэмжсэн” санал техникийн saatlyin улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын “дэмжсэн” санал техникийн saatlyin улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.14 дэх хэсгийн “программ, эсхүл санал хураах хуудсаар явуулна.” гэснийг “программ ашиглан явуулна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 17, 18, 19, 20 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 17, 18, 19, 20 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**Н.Энхболд:** 6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийн “хуулийн” гэснийг “хууль, тогтоолын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 33 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 33 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**8.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “зааснаас” гэснийг “заасан болон олон улсын гэрээ соёрхон батлахаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**9.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсгийн “энэ хуулийн 31.2-т заасан Засгийн газрын гишүүн” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 35, 36 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 35, 36 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**10.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийн “Энэ хуулийн 37.1-д” гэснийг “Энэ хуулийн 37.1, 37.2, 37.3-т” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 37, 38 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 37, 38 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**11.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсгийн “тайлбарлаагүй” гэснийг “бичээгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58, 59, 60, 61, 62, 63, 64, 65, 66, 67, 68 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58, 59, 60, 61, 62, 63, 64, 65, 66, 67, 68 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**12.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 70, 71, 72, 73, 74, 75, 76, 77, 78, 79, 80, 81, 82, 83, 84, 85, 86, 87, 88, 89, 90, 91, 92, 93, 94, 95, 96, 97, 98, 99, 100, 101, 102, 103, 104, 105, 106, 107, 108, 109, 110, 111, 112, 113, 114 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 70, 71, 72, 73, 74, 75, 76, 77, 78, 79, 80, 81, 82, 83, 84, 85, 86, 87, 88, 89, 90, 91, 92, 93, 94, 95, 96, 97, 98, 99, 100, 101, 102, 103, 104, 105, 106, 107, 108, 109, 110, 111, 112, 113, 114 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**13.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 115 дугаар зүйлийн 115.2.6 дахь заалтын “жил бүр” гэсний дараа “, Төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендерийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг 2 жил тутам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**14.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 115.2.18 дахь заалт нэмэх:

“115.2.18.хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг Төсвийн байнгын хороо жил бүр” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**15.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 115 дугаар зүйлийн 115.3 дахь хэсгийн “тайланг” гэснийг “мэдээллийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**16.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 115 дугаар зүйлийн 115.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“115.4.Энэ хуулийн 115.2, 15.3-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын мэдээллийн нэгдсэн санд байршуулж, энэ хуулийн 115.2-т заасан тайланда ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 116, 117, 118, 119 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 116, 117, 118, 119 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**17.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“120.3.Байнгын хороо сонсгол зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 121, 122, 123, 124, 125, 126, 127, 128, 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 121, 122, 123, 124, 125, 126, 127, 128, 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**18.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 134 дүгээр зүйлийн 134.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 135, 136, 137 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 135, 136, 137 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

**Н.Энхболд:** **19.**Ажлын хэсгийн гаргасан, Зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

#### Найруулгын санал:

**Н.Энхболд:** **1.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “хуралдаанд оруулж” гэсний дараа “, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар” гэж, 121 дүгээр зүйлийн 121.6 дахь хэсгийн “121.1-д” гэсний өмнө “энэ хуулийн” гэж тус тус нэмэх.

**2.**Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “дуусахаас” гэснийг “хаахаас” гэж өөрчлөх, 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “9.16-д” гэснийг “9.15-д” гэж, 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсгийн “буую” гэснийг “, эсхүл” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “хоног” гэснийг “өдөр” гэж өөрчлөх, 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “53.1-д” гэснийг “52.1-д” гэж, 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсгийн “50.2-т” гэснийг “52.2-т” гэж, мөн зүйлийн 53.6 дахь хэсгийн “38, 39, 40, 41, 42, 43 дугаар” гэснийг “39, 40, 41, 42, 43, 44 дүгээр” гэж, 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийн “27 дугаар” гэснийг “28 дугаар” гэж, 95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсгийн “90.2-т” гэснийг “95.2-т” гэж, мөн зүйлийн 95.9 дэх

хэсгийн “95.7-д” гэснийг “95.8-д” гэж, 98 дугаар зүйлийн 98.4 дэх хэсгийн “86, 87” гэснийг “85, 86” гэж, 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсгийн “26 дугаар” гэснийг “24 дүгээр” гэж, 117 дугаар зүйлийн 117.9 дэх хэсгийн “120.6-д” гэснийг “117.6-д” гэж, 119 дүгээр зүйлийн 119.5 дахь хэсгийн “126.6-д” гэснийг “129.1-д” гэж, 123 дугаар зүйлийн 123.3 дахь хэсгийн “127.5-д” гэснийг “126.5-д” гэж, 127 дугаар зүйлийн 127.2 дахь хэсгийн “7 дугаар” гэснийг “17 дугаар” гэж тус тус өөрчлөх.

**3.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “багтаан” гэснийг, 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийн “, эцэслэн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.**

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

-Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**Н.Энхболд:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 41.4 дэх хэсгийн “шаардлагатай гэж үзвэл” гэсний дараа “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу” гэж нэмж, 4.6 дахь хэсгийн “багтаан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|   |    |
|---|----|
| Зөвшөөрсөн:                               | 5  |
| Татгалзсан:                               | 5  |
| Бүгд:                                     | 10 |
| 50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. |    |

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 41.4 дэх хэсгийн “шаардлагатай гэж үзвэл” гэсний дараа “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу” гэж нэмж, 4.6 дахь хэсгийн “багтаан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4, 5, 6, 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4, 5, 6, 7 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын З гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Баярмаа, Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, А.Наранцэцэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

-Төслийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**Н.Энхболд:** 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “байгуулалтын” гэсний дараа “болон энэ хуулийн 9.2.1, 9.2.2-т заасан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|   |    |
|---|----|
| Зөвшөөрсөн:                               | 5  |
| Татгалзсан:                               | 5  |
| Бүгд:                                     | 10 |
| 50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. |    |

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                                    | 6  |
| Татгалзсан:                                    | 4  |
| Бүгд:  | 10 |
| 60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. |    |

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “байгуулалтын” гэсний дараа “болон энэ хуулийн 9.2.1, 9.2.2-т заасан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 10, 11, 12, 13, 14 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 10, 11, 12, 13, 14 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**Н.Энхболд:** 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтын “жил бүр” гэсний дараа “, төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендерийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг 2 жил тутам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн ард 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.18 дахь заалт нэмэх:

“15.1.18.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг жил бүр.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.4, 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.3.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурлын хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор мэдээллийн нэгдсэн сан болон Улсын Их Хурлын цахим хуудаст нийтэлж, байршуулна.

15.4. Энэ хуулийн 15.1-д заасан тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газрын дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна.

15.5. Байнгын хороо энэ хуулийн 15.1-д заасан тайлан, илтгэл, мэдээллийг энэ хуулийн 15.3-т заасан дүн шинжилгээ яаманд хэлэлцэн, шаардлагатай гэж үзвэл шийдвэрийн төсөл боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

-Төслийн 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**5.** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “7-31” гэснийг “7-15” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

**6.** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.3 дахь хэсэг нэмж, 33.3, 33.4, 33.5, 33.6, 33.7 дахь хэсгийн дугаарыг 33.4, 33.5, 33.6, 33.7, 33.8 гэж өөрчлөх:

“33.3. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргээ хавсран гүйцэтгэж байгаа гишүүн түр хорооны бүрэлдэхүүнд ажиллахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

-Төслийн 34, 35, 36, 37 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 34, 35, 36, 37 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**7.** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсгийг “Тайлбар” болгон доор дурдсанаар өөрчилж, 38.9, 38.10, 38.11, 38.12, 38.13, 38.14 дэх хэсгийн дугаарыг 38.8, 38.9, 38.10, 38.11, 38.12, 38.13 гэж өөрчлөх:

**“Тайлбар:** Энэ хэсэгт заасан “хүндэтгэн үзэх шалтгаан” гэдэгт хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан бусад гамшиг тохиолдсон, албан томилолттой байгаа, эрүүл мэндийн шалтгаантай, мэдэгдэх хуудас хүргүүлэхээс өмнө гадаад улсад байгаа зэрэг хувь хүнээс өөрөөс нь үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

**8.** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.12 дахь хэсгийн “холбогдох төрийн байгууллага” гэснийг “төрийн болон нутгийн захиргааны холбогдох байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|   |    |
|---|----|
| Зөвшөөрсөн:                               | 5  |
| Татгалзсан:                               | 5  |
| Бүгд:                                     | 10 |
| 50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. |    |

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                                    | 6  |
| Татгалзсан:                                    | 4  |
| Бүгд:  | 10 |
| 60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. |    |

**Н.Энхболд:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.12 дахь хэсгийн “холбогдох төрийн байгууллага” гэснийг “төрийн болон нутгийн захиргааны холбогдох байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

|  |    |
|--|----|
| Зөвшөөрсөн:                            | 6  |
| Татгалзсан:                            | 4  |
| Бүгд:                                  | 10 |
| 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ. |    |

**Н.Энхболд:** 9. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийн “Хувь хүн нь” гэснийг “Шинжээч, хянан шалгагчийг сонгож авах,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

*Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

#### Найруулгын санал:

**Н.Энхболд:** 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн “төсвийн хяналт, шинжилгээний” гэсний өмнө “Тамгын газрын” гэж, төслийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн “даруй” гэсний өмнө “нэн” гэж, төслийн 35 дугаар зүйлийн 35.7.5 дахь заалтыг “даргалах” гэсний дараа “, хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах” гэж, төслийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийн “хадгалах” гэсний дараа “, сонгох” гэж тус тус нэмэх.

2. Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн” гэснийг “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, /цаашид “хууль, тогтоомж” гэх/-ийн” гэж, төслийн 1 дүгээр зүйлийн 1.1, 12 дугаар зүйлийн 12.1, 12.6, 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн” гэснийг “хууль тогтоомжийн” гэж, төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “бодлогын баримт бичгийн” гэснийг “бодлого, төлөвлөлтийн” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийн “Асуудал хариуцсан” гэснийг “Холбогдох” гэж, мөн хэсгийн “танилцуулж болно.” гэснийг “танилцуулна.” гэж, төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “энэ хуулийн 54.1-д” гэснийг “энэ хуулийн 48.1-д” гэж, төслийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “хэвлэл мэдээллийг” гэснийг “хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг” гэж, төслийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн “хэн бүхэн” гэснийг “оролцогч” гэж, төслийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “санал, дүгнэлтийг” гэснийг “санал, дүгнэлт, шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төслийг” гэж, төслийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн “, Зөрчлийн тухай, эсхүл бусад хуульд заасан хариуцлага оногдуулна.” гэснийг “болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага оногдуулна.” гэж тус тус өөрчлөх.

3. Төслийн 9 дүгээр зүйлийн 9.12 дахь хэсгийн “Байнгын хорооноос байгуулах” гэснийг, төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “заавал” гэснийг, төслийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн “хөөж” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Төсвийн тогтвортой байдлын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийтийн сонсголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 16 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

**Дөрөв. “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Б.Баярмаа, Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогох, А.Наранцэцг нар байлцав.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

**Н.Энхболд:** “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|                                  |    |
|----------------------------------|----|
| Зөвшөөрсөн:                      | 6  |
| Татгалзсан:                      | 4  |
| Бүгд:                            | 10 |
| 60.0 хувийн саналаар дэмжигдлээ. |    |

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 16 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 57 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 27 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Н.ЭНХБОЛД

**Тэмдэглэл хөтөлсон:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
14 цаг 30 минут

## БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Н.Энхболд:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Төрийн байгуулалтын байнгын хорооны олонх хүрэлцэн ирж ирц бүрдлээ. Байнгын хорооны 2024 оны 04 сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ.

**Нэгдүгээрт.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд.

Төслүүдийг Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024 оны 04 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн. Өнөөдөр анхны хэлэлцүүлэг хийнэ.

### Нэг. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

/Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 3 гишүүн 2024.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Ажлын хэсгийн нэрсийг өгчихье. Өнөөдрийн асуудлуудыг хэлэлцэхэд ажлын хэсгээр Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Улсын Их Хурлын Тамгын

**Хоёрдугаарт.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Мөн Н.Энхболд нарын 3 гишүүн 04 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг хийнэ.

**Гуравдугаарт.** Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Н.Энхболд нарын 3 гишүүн 04 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг хийнэ.

**Дөрөвдүгээрт.** “Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Эцсийн хэлэлцүүлэг хийнэ. Засгийн газар 2022 оны 01 сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн төсөл байгаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

газрын Хууль эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар оролцож байгаа.

Хуулиудыг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг Д.Тогтохсүрэн гишүүн ахалж ажилласан.

Дэд ажлын хэсгүүд, ажлын хэсэг хуралдаад өнөөдрийн материалуудыг бэлдэж Та бүхэнд тараасан байгаа.

Ингээд ажлын хэсгийн танилцуулгыг тус ажлын хэсгийн ахлагч, Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулна.

Д.Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

**Д.Тогтохсүрэн:** Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Л.Мөнхбаатар, Г.Тэмүүлэн нараас 2024 оны 04 сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон тэдгээртэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар, Улсын Их Хурал 2024 оны 04 сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 54 дүгээр захирамжаар Монгол Улсын Их

Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгээр ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд ажлын дэд хэсэг 4, ажлын хэсэг 2 удаа тус тус хуралдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.9 дэх хэсэгт “хэрэв тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулсан бол тухайн ажлын хэсэг хуулийн төслийн талаар тусгайлсан саналаа эрхлэх асуудалд нь хамаарах Байнгын хороонд танилцуулна” гэж заасны дагуу Улсын Их Хурлын **D-Parliamen.mn** цахим системд иргэдээс ирүүлсэн 1 санал, ажлын хэсгийн гишүүн Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ж.Сүхбаатар нараас ирүүлсэн 3 санал, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтuyaа, Г.Тэмүүлэн Г.Тэмүүлэн нараас болон Жендэрийн үндэсний хорооноос ирүүлсэн саналуудыг үндэслэн ажлын хэсэг дараах саналуудыг гаргаж Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж байна.

**Нэг.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар 14, хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслийн талаар 4, нийт 18 зарчмын зөрүүтэй саналын томьёолол, мөн найруулгын 5 саналын томьёолол бэлтгэлээ. Үүнд:

Улсын Их Хурал өөрийн стратеги төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр нэг нам эвслээс албан ёсоор нэр дэвшиж 10 ба түүнээс дээш гишүүн сонгогдсон бол уг гишүүн нийлж нам, эвслийн бүлэг байгуулснаар нам, эвслээс яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн Эрүүгийн хэрэг хэрэгтэй холбоотой асуудлаар Хянан шалгах түр хороог байгуулахгүй гэснийг яллагдагчийг шүүхэд шилжүүлснээс хойш 2 жил гэж тодорхой хугацаатай болгохоор, мөн түүнчлэн Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн Хянан шалгах түр хорооны дарга, гишүүнээр ажиллахгүй байх зэрэг, мөн Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай саналууд.

Энэ дэгийн хуулийг бас хамт танилцуулчих уу?

**Н.Энхболд:** Тэгье. Нэгмөсөн танилцуулах нь зөв.

**Д.Тогтохсүрэн:** Хоёр. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар нийт 19 зарчмын саналын зөрүүтэй санал, найруулгын 3, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй 1 саналын томьёолол боловсруулсан бөгөөд дараах зарчмын өөрчлөлтуудийг орууллаа. Үүнд:

Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль

тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлэх.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвийн орлого, хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг сонсох бөгөөд саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах.

Төрийн байгуулалтын байнгын хороо Төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендерийн ялгаварлан гадуурхал, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг 2 жил тутам хэлэлцэх.

Төсвийн байнгын хороо хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг жил бүр хэлэлцэх.

Мөн Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналтай нийцүүлсэн холбогдох саналууд.

**Гурав.** Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар ажлын хэсгийн дэмжсэн 9 зарчмын зөрүүтэй санал болон найруулгын 3 багц саналын томьёоллийг бэлтгэж Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1. Улсын Их Хуралд ирүүлдэг тайлан мэдээлэл, мэдээллийн хамрах хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендерийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг сонсдог байхаар Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний албан үргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн Хянан шалгах түр хорооны дарга, гишүүнээр ажиллахгүй байх, Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд ажиллах гишүүдийн тоог шинээр тогтоох зэрэг саналуудаа боловсрууллаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон тэдгээртэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх ажлын хэсгийн танилцуулах зарчмын зөрүүтэй саналын томьёоллийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Н.Энхболд:** Ажлын хэсгийн ахлагч Д.Тогтохсүрэн гишүүнд баярлалаа.

Чуулганы хуралдаан дэгийн тухай хуулиар Байнгын хороо 39.10-д заасны дагуу хуулийн төсөл зүйл бүрээр нь хэлэлцэж батлах ёстой.

Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулж хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно.

Дэгийн тухай хуулийн 13.1.2-т асуулт асуух хугацаа 4, нэмэлт асуулт асуух хугацаа 1, дахиад 1 минутаар сунгаж болохоор зохицуулсан байгаа.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлнэ.

Тухайн зүйлтэй холбогдуулаад хууль санаачлагчаас, ажлын хэсгээс асуулт асууж болно.

Санал хураах ажилдаа орьё.

Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

4 дүгээр зүйл дээр зарчмын зөрүүтэй саналууд байгаа. Ажлын хэсгээс ирсэн саналууд байгаа. Үүнийг уншиж танилцуульяа.

1. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.5, 4.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.5. Улсын Их Хурал тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас, шагналтай байна.

4.6. Улсын Их Хурлын оноосон нэртэй адил утга, агуулгатай нэр, нэрийн товчлолыг зөвшөөрөлгүй ашиглахыг хориглоно.

Ажлын хэсгийн гишүүн Д.Тогтохсүрэн, Х.Болорчулуун, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж нарын гаргасан санал байгаа. Ж.Сүхбаатар гишүүн орсон байгаа.

Энэ саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья. /алх цохив/

10-аас 6 дэмжиж, 60.0 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.8 дахь хэсэг нэмэх:

“4.8. Улсын Их Хурал өөрийн стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.” Санал хураалт. /алх цохив/

10-аас 6 дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хуулийн 5 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

6 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

7 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

8 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

9 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

10 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

11 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна. /алх цохив/

12 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн.

12 дээр С.Одонтuya гишүүний микрофоныг өгье.

**С.Одонтuya:** Тэгэхээр миний ажлын хэсэгт өгсөн санал бол 44 дүгээр зүйл гишүүнд хориглох үйл ажиллагаа гэдэг дээр санал өгсөн тэгээд энд алинд нь ч ороогүй байна.

44.1.16-г нэмж оруулж өгөөч ээ гэсэн санал гарсан.

**Н.Энхболд:** Тэр үед нь ярьчихъя.

**С.Одонтuya:** Үгүй ээ, тэр нь харин байхгүй. Одоо өнгөрөх гээд байгаа байхгүй юу.

Одоо шууд дараагийн 46 руу орох гээд байгаа юм.

**Н.Энхболд:** Биш ээ. Бид дөнгөж 13 дугаар зүйл дээр л явж байна.

Та 44 дүгээр зүйл дээр очихдоо. Таных 29 дээр, 30-н хэд дээр байгаа.

**С.Одонтuya:** Харин 44 дүгээр дээр очих юм байхгүй юм байна шүү дээ. Энд.

**Н.Энхболд:** Байлгүй яах вэ.

**С.Одонтуяа:** Харин тэр чинь сая асууж байна шүү дээ. 11-ээс нь.

**Н.Энхболд:** Биш ээ. 44 байгаа. Зүйл бүрээр явдаг юм. Тийм. Яг тэр үед нь хэлчхээрэй.

13 дугаар зүйл дээр ажлын хэсгээс гаргасан саналууд байгаа. Танилцуулъя.

3.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “хэлэлцэх нийт хугацааг тогтоох” гэснийг “хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр тогтоох” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

10-аас 6. 60.0 хувиар дэмжлээ.

Төслийн 14 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Төслийн 15 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Төслийн 16 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Төслийн 17 дугаар зүйл дээр санал асуулттай гишүүн алга байна. /алх цохив/

Төслийн 18 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Төслийн 19 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Төслийн 20 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Төслийн 21 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс ирсэн санал байгаа.

Үүнийг одоо санал хураана. М.Оюунчимэг гишүүн ороод ирэг. Тэгэхээр нь хураачихъя хэдүүлээ. Тэгэх үү.

Эсвэл саналгүй юмнуудаа явж байж болно биз дээ. Заавал дэс дараагаар нь уншихгүй саналгүй юмнуудаа явж байвал ясан юм. Энэ хооронд. Асуулт санал байхгүй юм чинь.

21 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс ирүүлсэн оруулж ирсэн санал байгаа.

4.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.25 дахь хэсгийн “үл хүндэтгэсэн үйлдэл гэж үзнэ.” гэснийг “үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж өөрчлөх.

Ажлын хэсгийн санал. Дэмжье. Санал хураалт. /алх цохив/

10-аас 6 дэмжиж, 60.0 хувиар дэмжигдлээ.

Төслийн 22 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна. /алх цохив/

23 дугаар зүйл дээр асуулт, санал алга байна. /алх цохив/

24 дүгээр зүйл дээр асуулт, санал алга байна. /алх цохив/

25 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

26 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

27 дугаар зүйл дээр ажлын хэсгээс ирсэн санал байгаа.

5.Төслийн 27 дугаар зүйлийн 27.5.4 дэх заалтын “бүрэн эрхтэй холбогдсон асуудлыг” гэсний өмнө “халдашгүй байдал,” гэж нэмэх. Санал хураалт. /алх цохив/

10-аас 6 хүн дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

Мөн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.12 дахь хэсэг нэмэх:

“27.12.Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.”

Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. /алх цохив/

Энэ яачхав. Өө минийх орсонгүй. Уучлаарай. Энэ саналыг хүчингүй тооцох зарчмын санал гаргаж байна. Горимын санал гаргаж байна. Дэмжиж өгөхийг хүсье. Санал хураалт. /алх цохив/

6 гишүүн дэмжиж, 60.0 хувиар дэмжигдлээ.

Горимын саналаар түрүүчийн санал хураалтын дүng хүчингүй болгосон.

Одоо түрүүчийнхээ томъёоллоор санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. Гишүүд ээ. /алх цохив/

6 гишүүн дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдэж байна.

Төслийн 22 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Төслийн 23 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Төслийн 24 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Төслийн 28 дугаар зүйл дээр ажлын хэсгээс ирсэн санал байна.

7.Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “хянан шалгагч томилох, бичиг баримтад дүн шинжилгээ хийх зэрэг” гэснийг “хянан шалгагч, шинжээч томилох, бичиг баримтад дүн шинжилгээ хийх, гэрчээс мэдүүлэг авах зэрэг” гэж өөрчлөх.

Ажлын хэсгийн санал. Найруулга дээрээ анхаараарай. Санал хураалт. /алх цохив/

10-аас 6 дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

8.28 дугаар зүйлийн 28.5.3 дахь заалтын “яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар” гэснийг “яллагдагчийг шүүхэд шилжүүлснээс хойш хоёр жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудлаар” гэж өөрчлөх.

Ажлын хэсгийн санал. Дэмжье. /алх цохив/

10-аас 6 дэмжиж, санал дэмжигдлээ.

9.28 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 28.6, 28.11 дэх хэсэг нэмэх:

“28.6. Тухайн ээлжит чуулганы хугацаанд хоёр хүртэл хянан шалгах түр хороо ажиллаж байгаа бол Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хянан шалгах түр хороо байгуулах саналыг дараагийн ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэнэ.

28.11. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хянан шалгах түр хорооны дарга, гишүүнээр ажиллахгүй.”

Ажлын хэсгийн санал. Дэмжье. /алх цохив/

10 гишүүнээс 6 нь дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

28 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

29 дүгээр зүйл. Энэ дээр ажлын хэсгээс санал байгаа. Б.Пүрэвдорж гишүүнээс гаргасан санал бий.

Эхлээд ажлын хэсгийн саналаа хураалгачихъя.

Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.4, 29.13 дахь хэсгийн “12” гэснийг “10” гэж, мөн зүйлийн 29.4, 29.9 дэх хэсгийн “12-oos” гэснийг “10-аас” гэж тус тус өөрчлөх.

Энэ нь нөгөө бүлэг байгуулах гишүүдийн босгыг буулгаж байгаа юм. Тийм. Санал хураалт. /алх цохив/

10-аас 6 гишүүн дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

Б.Пүрэвдорж гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 29.3-ыг бүлэг даргаа гишүүдийн олонхын саналаар сонгож бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрийн жагсаалтыг бүлгийн дарга бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлгийн эрх, үүрэг хэрэгжиж эхэлнэ.

Тийм. Одоогийнх дээр ч байгаа. Өнөөдрийнх дээр ч байгаа. Бичгээ явуулчихад л болоо. Тэр уншина уу, уншихгүй байна уу. Тэр хамаагүй.

Б.Пүрэвдорж гишүүний саяын саналыг дэмжье гэсэн санал хураалт. Дэмжье. Санал хураалт. /алх цохив/

Хөөе энэ хэнийх вэ? Чи өөрөө Б.Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж гишүүн саналаасаа татгалзаж байгаа юм байлгүй дээ. Микрофоныг нь өгье. Б.Пүрэвдорж гишүүний.

**Б.Пүрэвдорж:** Манай дарга бас хажуугаас юм ярьж байгаад би хариуцлагагүй хандаад кнopoо буруу дарчихлаа.

Тэгээд дахиж санал хураалгаж өгөөч.

**Н.Энхболд:** Саяын санал хураалтыг хүчингүй тооцсон горимын саналыг дэмжье. Б.Пүрэвдорж гишүүний

санал. Санал хураалт. Гишүүд ээ. /алх цохив/

Саяын санал хүчингүй боллоо.

Дахиад түрүүчийн уншсан томьёоллоороо, Б.Пүрэвдорж гишүүний саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

10-аас 6 гишүүн дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

29 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа. /алх цохив/

30 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

31 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна. /алх цохив/

32 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн.

Ажлын хэсгээс санал байхгүй. Б.Пүрэвдорж гишүүнээс 32.1-д “бүлэг” гэсний дараа “бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаандаа” гэж нэмэх.

Та саналаа тайлбарлаачих. Тийм. Б.Пүрэвдорж гишүүний микрофоныг егье.

**Б.Пүрэвдорж:** Энэ ажлын албаны хүмүүстэй холбоотой заалттай байгаа юм.

Тэгэхээр манай бүлэг дээр түрүүчийн бүлэгт ажиллаж байсан хүмүүс өргөдөл, гомдол гаргаад тэгээд саяхан шийдээд. Бас тэр нь орно гээд л янз янзын асуудал болдог.

Тийм учраас “бүрэн эрхийн хугацаандаа” гэдэг зүйлийг оруулж байгаа юм.

Бүрэн эрхийн хугацаандаа л тухайн бүлэгт ажилласан хүн тэндээ ажиллаад л. Хэрвээ дараа нь улирахаар бол тэр нь дахиад томилгоогоор явна гэсэн үг.

**Н.Энхболд:** Ерөөсөө “бүрэн эрхийг хэрэгжүүлэх хугацаандаа л” гэсэн санаа нэмэгдэж байгаа юм байна. Дэмжье гэдгээр санал хураалт явуулчихъя. Санал хураалт. /алх цохив/

6 гишүүн дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

29 дүгээр зүйлээр зүйлийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төслийн 30 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

31 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

32 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

33 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

34 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

35 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

36 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

37 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

37 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

38 дугаар зүйл дээр ажлын хэсгээс ирсэн санал байгаа.

Төслийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийг хасах.

Хэвлэлийн эрх чөлөөний хуулттай уялдуулаад энэ томьёолол, зүйлийг хасаж байгаа юм. Дэмжье гэсэн санал хураалт явууллаа. Санал хураалт. /алх цохив/

Нэг нь үлдчихлээ дээ бас. Д.Сарангэрэл гишүүний микрофоныг өгье.

**Д.Сарангэрэл:** Би дарга аа дэмжиж санал өгсөн. Эсрэг гарчихлаа. Саяын саналыг хүчингүй болгож өгнө үү.

**Н.Энхболд:** Д.Сарангэрэл гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

6 гишүүний саналаар түрүүчийн санал хураалтын дун хүчингүй боллоо.

Одоо эргээд уншсан томьёоллоороо санал хураалт.

Төслийн 38.3 дахь хэсгийг хасах. Санал хураалт. /алх цохив/

6 гишүүн дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

38 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

39 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

40 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна. /алх цохив/

41 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй байна. /алх цохив/

42 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

43 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

44 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

45 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Таных 44 дээр билүү? Томьёолол чинь хаана байна? Наашаа өгчих.

44.1.16 болгож гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд иргэд, сонгогчдод тайлангаас бусад эд, зүйлс тараах, аливаа хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлдэл, үйл ажиллагааг хийхгүй байх гэсэн саналыг.

Бүрэн эрхийнхээ хугацаанд. С.Одонтuya гишүүн гаргасан юм байна.

Ажлын хэсэгт саналаа өгч байсан юм байна.

Энэ тал дээр тайлбараа ажлын хэсгийн ахлагч Д.Тогтохсүрэн та нэг тайлбар өгчих.

**Д.Тогтохсүрэн:** С.Одонтuya нарын 8 гишүүн байсан уу? Нэлээн олон гишүүн бий.

8 гишүүнээс санал ирсэн юм. Саяын Н.Энхболд гишүүний уншдаг

44.1.16 дээр гишүүний бүрэн эрхийн хугацаанд иргэд, сонгогчдоос тайлангаас бусад эд зүйл тараах, аливаа хэлбэрээр үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлдэл, үйл ажиллагааг хийхгүй байх гэсэн ийм заалт байгаа юм.

Үүнийг ажлын хэсэг дээр юу гэж ярьсан гэхээр ерөөсөө олон улсын туршлага нэгдүгээрт юу гэж үзэж байна вэ гэхээр иргэдийн эрхийг хэтэрхий хааж болохгүй ээ.

Энэ чинь Улсын Их Хурлын гишүүн гээд төр төлөөлчихсөн чинь нөгөө төлөөллийн юмаа хэрэгжүүлэх гэсэн чинь болохгүй байж болохгүй. Тухайлбал, одоо юу гэдэг юм тусlamж хүснээс эхлээд энэ чинь маш олон асуудал, харилцаа байгаа.

Ингээд тусlamж хүсдэг, тэгээд зөндөө олон юм. Дурсгалын зүйл байтугай л иргэд, сонгогч нартаа өгөх болдог.

Тэгээд нэг жижигхэн үзэг, бал ч юм уу. Тийм ээ. Ийм юмнууд бүгд хоригдчих юм. Нэг талаасаа.

Хоёрдугаарт, ерөөсөө олон улсын парламентад туршлага нь юу байдаг вэ гэхээр юм тараахыг хорьдоггүй.

Зүгээр сонгуульд нөлөөлөх гэж байна гэдгээрээ сонгуулийн жилээ бол хорьж болдог. Бусад жилээ бол хорьдоггүй юм байна.

Ганцхан эх үүсвэрээ л тайлбарла гэдэг л асуудал байдаг юм байна.

Та одоо юу гэдэг юм, ийм юм өгсөн бол. Бид үүнийг ярьсан. Хоёр янзаар үздэг юм уу. Мөнгө, эд зүйл гэж

үздэг юм уу гэж бид нар ярьсан юм. Томьёололыг нь өөрчилж.

“Мөнгө, эд зүйл тараахыг хориглоно” гэж оруулдаг юм уу гэж. Гэтэл нөгөө эд зүйл гэдэгт жишээлбэл дурсгалын юм ороод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бол одоо ингэж авч үзэж ерөөсөө болохгүй юм байна гээд.

Тэгээд ажлын хэсэг дээр яриад олонхоороо дэмжих боломжгүй гэж үзсэн юм. Энэ бол хэтэрхий нэг талаасаа иргэд, сонгогчдынхоо нөгөө хандах эрхийг нь хаагаад явчих гээд байгаа юм.

Нөгөө талаасаа гишүүдийг хэт ажиллах ямар ч боломжгүй болгож бас хаагаад.

Ингээд төр иргэн хоёрын хоорондын харилцаанд ч хүртэл энэ сөргөөр нөлөөлөх юм байна.

Харин зүгээр тэр эд мөнгө тараавал түүнийхээ эх үүсвэрийг тайлбарладаг юм уу, яадаг ийм л зүйл байх ёстой л гэж ингэж үзэж байгаа юм.

**Н.Энхболд:** Ж.Сүхбаатар гишүүн. Ажлын хэсгийн гишүүн.

**Ж.Сүхбаатар:** С.Одонтuyaа гишүүн ээ, ийм байгаа юм.

13 жилийн өмнө Сонгуулийн хуулийн ажлын хэсгийг нь Н.Энхболд дарга ахлаад, би Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга байсан юм.

Тэгээд сонгуулийн жилийн эхнээс хориглоё гэдгийг би санал гаргаж оруулсан юм. Анх Монгол Улсын хуульд.

Тэгэхэд одоо манай олон гишүүд Ардчилсан нам, Ардын намынхан бол амьдралгүй гэж хэлж байсан байхгүй юу.

Би арай гэж бодож бодож сонгуулийн жилээс хойш энэ бэлэг дурсгал, элдэв эд зүйл тараахыг нь хориглох заалтыг тэр үедээ бараг амьдралгүй гэж байхад хийгээд тэгээд хэвшүүлсэн юм.

Яг наана нь ингээд хориглоё гэдэг юм яриад зарим нэг хүн тэр үед ажлын хэсэгт ярьж байсан юм.

Тэгээд тэр нь болохоор ингээд хардаа, та өөрөө боддоо, дэлхийн улс орнуудад тийм юм байгаагүй.

Парламентын гишүүн төрийн далбаатай нэг ийм тэмдэг ч гэдэг юм уу, эсвэл өөрийнхөө С.Одонтuya гэсэн балаа ч юм уу, эсвэл бэлэг дурсгалын ч юм уу, ийм зүйлүүдийг өгье гэхээр энэ чинь хориотой болчихно.

Дээр нь нэг хүн 100 мянган төгрөгийн тусlamж үзүүлээч гэвэл. Би бүр 100 мянгыг ярьж байна шүү дээ. Сая төгрөгийн гээд. Бид нарт чинь дандаа хүсдэг.

Гэтэл ингээд цалингаа хандивлана гээд зарим нь ч ярьдаг.

Гэтэл энэ болгоныг ингэж хөөцөлдөж 4 жилийн хугацаанд болохгүй гэхэд бол хэцүү.

Одоо жишээлбэл Б.Пүрэвдорж гишүүн чинь тойрог дээрээ сонгогчдодоо шөл уулгаж байна гээд л асуудал болж байсан шүү дээ.

Түүн шиг ер амьдрал дээр юу хардаг вэ гэхээр энэ авлигын мөнгө үү

гэдгийг чинь л тодруулдаг байхгүй юу. Татвар төлсөн мөнгө байвал.

Та жишээлбэл маш их орлого олоод татвар төлсөн мөнгөнөөсөө буян үйлдэж байгаа бол тэрийг чинь бүр бахархалтай нь аргагүй, бусад улс орны парламентын гишүүд жилийн эцэст би ийм “**donation**”<sup>1</sup> буюу ийм хандив, тусlamжийг үзүүлсэн гэдгээрээ харин ч нийгэмд сайшаагддаг байхгүй юу.

Гол юм нь юу юм бэ гэхээр тэрийг тараагаад байгаа эх үүсвэрийг нь бид зарладаггүй. Тэгээд ойлгомжгүй шалтгаанаар.

Тэгвэл манай парламент цаашдаа зүгээр ёс зүйн хороондоо ч гэдэг юм уу, янз бүрийн юмандаа мэдэгдээд бэлэг дурсгалын зүйлийнхээ эх үүсвэрийг тайлбарладаг байх ёстой.

Жишээлбэл, Америкт “**Ёс зүйн комисс**” нь болохоор бэлэг дурсгалын зүйл тараах гэж байвал энэ нийцэж байна уу, үгүй юу гээд парламентын гишүүн “**Ёс зүйн комисс**” руугаа зөвлөгөө авдаг байхгүй юу. Одоо ингэж болж байна уу, үгүй юу гэж.

Тэгэхгүй ингээд шууд популист маягаар юу ч өгөхгүй гээд хэлчихээр нөгөө парламентын гишүүнийгээ тусlamж үзүүлэх ганц хүн гээд бодож байна. Дээр нь бас олон буяны байгууллагууд байдаг.

Гэтэл энэ дэлхий даяар та өөрөө бол том улс төрчид жилд одоо жишээлбэл юу гэдэг юм, Б.Обама ч гэдэг юм уу, эсвэл тэр сенатор ч гэдэг юм уу, манай гэр бул татвар төлөгдсөнийхөө

<sup>1</sup> “**donation**” хүн, байгууллагад туслахын тулд өгсөн мөнгө, бараа, эсвэл тэдэнд өгөх үйлдэл: хоол хүнс, мөнгө хандивлах.

дараах юмнаас бид ийм юм хийсэн гэдгээрээ харин ч үлгэр дуурайдал болдог байхгүй юу.

Тэгэхээр энэ зүг рүү явж, хүн цэвэр мөнгөнөөсөө юм бусдад өгөхийг өрөөсөө хорьдоггүй байхгүй юу.

Тэгэхээр энэ аргыг сонгуулийн жил эхэлснээс өмнөх рүү оруулахаар зүгээр амьдралгүй л юм гэж байгаа.

Дээр нь парламентын гишүүдийг ийм зүйлээр оруулчихаар Үндсэн хууль зөрчсөн ч гэдэг юм уу, хориглох зүйл дээр оруулчихаар Таныг ямар нэгэн асуудалд ороход асар эрсдэлтэй болгочиж байгаа байхгүй юу. Тэгээд асуудлууд.

Тэгээд тэр цэц ч тэрийг үзээд байж болохгүй. Эсвэл хэнд өгөх юм. Эрүүгийн хэрэг болгох юм уу. Энэ чинь их сонин болчход.

Сонгогчдын санал худалдаж авах асуудал гэдгийг бид “сонгуулийн жил” гэж бүр нэлээн асуудал болж байж арай гэж хийсэн эд байхгүй юу.

Түүнээс биш ярихгүй биш бид нар үүнийг ярьж үзсэн юм.

Одоо харин таны наад тавиад байгаа асуудал чинь бол ер нь татварын хяналт шалгалтай холбоотой асуудал.

Ер нь Монгол Улсын төрийн бүх өндөр албан тушаалтуудын татвар төлөлтийн байдал, буян хийж байгаа байдал эд нар чинь нээлттэй болох ёстой байхгүй юу.

Тэгж хийхгүй бол ингээд зүгээр ямар ч хандивын үйл ажиллагаа, тусlamжийн үйл ажиллагаанд оролцохгүй

гээд хориглоно гэдэг чинь жишээлбэл та бод л доо. Яагаад цалингаасаа янз бүрийн асуудал боллоо гэхэд 100, 100 мянган төгрөг нийлүүлээд тэр тойргийн юм уу, сонгогчийнхоо юманд бас өгч болохгүй гэж.

Энэ чинь санал худалдаж авч байна гэхэд хэцүү байхгүй юу. Яг сонгуулийн жилийн өмнө.

Зүгээр яах вэ бодит байдал. Түүнээс хориглочихсон улсын жишээ байвал та бас хэлж болно. Тийм юм бол байхгүй. Наадах чинь ёс зүйн кодекс, ёс зүйн комиссынхоо хүрээнд шийдэгддэг асуудал гэж л бид үзэж байгаа.

**Н.Энхболд:** С.Одонтуяа гишүүн өөрийнхөө санал дээр тайлбар хэлнэ. С.Одонтуяа гишүүний микрофоныг.

**С.Одонтуяа:** Та нар битгий их ийм ухаантай юм ярьж бай.

Та нар тийм ухаантай байсан юм бол энэ авлигал чинь яагаад ингээд өсөөд байгаа юм бэ? Тэр бусад орнууд чинь бол ёс зүйтэй хүмүүс байдаг байхгүй юу.

Ерөөсөө тэгж олноор нь юм тарааж байгаа газар та нар хаана харсан юм. Үүнийг чинь оруулахгүй бол одоо дараагийн сонгуулиас өмнө гараад л тэр боов шоу, нөгөө цагаан сараар хэдэн тэрбумаар нь тараана шүү дээ.

Та 100 мянга, 100 мянга гээд худлаа яриад байх юм байхгүй. За юу. Тэр чинь ёс зүйтэй орнууд, тэр чинь хяналттай байдаг юм. Сарын цалингаас нь хэтрэхгүй хэмжээний нэг, хоёр тусlamж үзүүлж болно шүү дээ.

Түүнээс биш хавтгайруулаад л. Одоо энэ заалтыг та нар оруулахгүй гэж

зүтгэж байгаад л хавтгайруулаад л юм тараах гэж байна.

Тэгээд санал худалдах, худалдан авах зорилгоор тараана.

Би юм тараасаар байгаад л дандаа гишүүн болдог хүмүүсийг би хэлж мэнднэ шүү дээ. Ганцхан би гаргасан биш 10 гаруй хүн үүнийг чинь яриад санал гаргасан юм.

Зүгээр энэ улс орныг нь авлигаас нь жоохон ч гэсэн багасгая, бас Их Хурлын гишүүд нь тараах юмандaa санаа зовоод байлгүй авлигат авах гээд л, түүндээ түүртээд байхгүй ерөөсөө улс орноо хөгжүүлдэг гишүүнийхээ үндсэн үүргийг л биелүүлье гэдэг ийм л зорилгоор хийсэн юм.

Гэтэл та нар бол авлигалаа ийм их өндөр болоод байгааг тэгвэл тайлбарлаж чадахгүй л байгаа шүү дээ. Иймэрхүү юман дээр л гишүүд өөрсдөө л үлгэрлэж байгаа шүү дээ. Тийм.

Битгий бусад оронтой харьцуул аа, бусад орон чинь ёс зүйтэй, шал өөр байдаг юм.

Тийм учраас энэ дээр оруулах юм бол яах вэ энэ улс төр чинь бас жоохон цэвэр л болох байсан юм.

Бид хориглоод болж л байсан шүү дээ. Нэг хэсэг чинь сонгуулиар баахан дуу хөгжимчид гар тараад л дуу хуурддаг байсныг нь болиулсан. Сонгуулийн жил юм тараадгийг нь болиулсан. Энэ чинь ингээд бас урагшилж байна шүү дээ.

Тэр байтугай дүүргийн иргэдийн Хурал, аймгийн иргэдийн Хурлынхан тэгж байна шүү дээ. Үүнийг одоо бүр зөвхөн гишүүд биш аймаг, орон

нутгийнхны хүртэл хэмжээнд үүнийг хийх ёстой гэж.

Тэгэхээр та нар энэ авлигыг дэмжиж байгаа юм байна гэж би шууд ойлголоо. Тарааж байгаа юмнууд чинь дандаа хэдэн тэрбумаас давчихсан юм байгаа шүү дээ.

**Н.Энхболд:** Д.Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа.

С.Одонтuya гишүүн ингэж гүйвуулж болохгүй л дээ. С.Одонтuya гишүүн ээ. Ингэж дэндүү нэг талаас нөгөө тал руу нь гүйвуулж болохгүй.

Та юу гэнэ ээ. Энэ чинь ийм байхгүй юу. Бид юу гэж үзсэн гэхээр нэгдүгээрт энэ чинь сонгогдсон хүний тухай асуудал ярьж байгаа юм. Сонгуулийн жил яриагүй.

Сонгуулийн жилтэй холбоотой асуудал бол та сонгогчдыг авлигадаж байна гэж хэлнэ. Үүнийг чинь тэр урлаг соёл, бүх юмыг нь хаачихсан.

Энэ чинь бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа гишүүний тэр 3 жилийн хугацаанд нь хийх ажилтай холбоотой асуудал.

Гэтэл амьдрал дээр чинь иргэн, гишүүн хоёрыг хооронд нь, өөрөөр хэлбэл та бол холдуулах гэж байгаа асуудал байхгүй юу.

Манай иргэд чинь зайлув гишүүндээ бүх юмаа ханддаг шүү дээ. Тэрийг нь бид бүгдийг нь хаах гэж байна шүү дээ. Ганцхан жилд нь юм уу, 2 жилд нэг цаас өгөхийг нь зөвшөөрөөд бусдыг нь хорьж болохгүй байхгүй юу.

Тэгээд нэгдүгээрт иргэд сонгогчдын хоорондын харилцааны асуудал.

Хоёрдугаарт, юу байна вэ гэхээр хэрэв үүнийг нээж өгөхгүй бол гишүүд иргэдтэйгээ огт ажиллаж чадахгүй. Сонгогчдод сонгогчийн эрх ашгийн асуудал маш том асуудал байхгүй юу.

Тэгэхээр та бол энэ хоёр асуудал хооронд нь зааглаж авч үз ээ. Тэгээд юм л болбол авлига гэж орилдог, юм л болбол буруутгадгаа болих хэрэгтэй.

Тайлангаас гадна иргэд тусламж хүснэ шүү дээ. Танаас. Эмчилгээний зардалд ингээч гэж хүснэ шүү дээ. Үүнийг яах юм бэ. Үүнийг бид хааж болохгүй шүү дээ. Амьдрал баян. Гэргүй хүн гэр гэнэ шүү дээ. Үүнийг яах юм бэ. Тийм.

Тэгэхээр үүнийг бид нар зөвхөн сонгуулийн жил хийхгүй. Бусад жилд нь тэр хийх нь чөлөөтэй байг. Ганцхан эх үүсвэрээ тайлбарла гэдэг л асуудал байхгүй юу.

Тэгэхгүй бид бүх юмыг явцуураад нэг цэгээс нь нөгөө цэгт нь аваачиж асуудалд хандаж би болохгүй л гэж л бодож байгаа юм.

Тэгээд л юм л болбол нөгөө авлигачид учраас дэмжихгүй байна гэж ингэж ярьдаг байдлаа цаашдаа болих хэрэгтэй шүү.

Та тэгж байна шүү дээ. Үгүй. Энэ чинь түүнтэй холбоогүй асуудал байхгүй юу.

**Н.Энхболд:** Саналаа хураая. С.Одонтuya гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн санал. Хэрэв дэмжигдэхгүй

бол цөөнх болоод чуулган дээрээ үүнийгээ ярьж болно. Санал хураалт. /алх цохив/

44 дүгээр зүйл явж байгаа шүү.

2 гишүүн дэмжлээ. Санал дэмжсэнгүй.

Цөөнх болно гэвэл протоколд тэмдэглүүлж байгаад чуулган дээр үгээ хэлж болно.

Дараагийн асуудалдаа орьё. Цөөнх болох уу?

46 дугаар зүйл дээр ажлын хэсгээс ирсэн санал байгаа.

12.Төслийн 46 дугаар зүйлийн 46.5.4 дэх заалтын “Хууль тогтоомжийн тухай хуульд” гэсний өмнө “энэ хуулийн 36 дугаар зүйл,” гэж нэмэх. Санал хураалт. /алх цохив/

10-аас 6-г дэмжиж,

45-ыг уншсан билүү? Тийм үү?  
Нөхөөд.

Хуулийн 45 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байхгүй юм байна шүү.

Цаашаа явъя. 46 дугаар зүйлийн хоёр дахь санал. Ажлын хэсгээс ирүүлсэн.

13.Төслийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай хоёр дахь өгүүлбэр нэмэх:

“Энэ журам нь Төрийн албаны тухай хуулийн 54.2, 55.2-т заасан журмаар зохицуулах харилцаанд хамаарахгүй.”

Ажлын хэсгийн санал. Дэмжье.  
Санал хураалт. /алх цохив/

10-aас 6 дэмжиж, санал  
дэмжигдлээ.

47 дугаар зүйл дээр асуулт,  
саналтай гишүүн байна уу? Алга байна.  
/алх цохив/

48 дугаар зүйл дээр асуулт,  
саналтай гишүүн алга байна. /алх цохив/

49 дүгээр зүйл дээр асуулт,  
саналтай гишүүн алга байна. /алх цохив/

50 дугаар зүйл дээр ажлын хэсгээс  
ирсэн санал байгаа.

**14. Төслийн 50 дугаар зүйлийн 50.2**  
дахь хэсгийг хасах.

Санал хураалт. /алх цохив/

50.2 гэдэг бол Улсын Их Хурлын  
ажиллагааны аюулгүй байдалтай  
холбоотой худалдан авах ажиллагааг  
зохион байгуулах журмыг Их Хурал  
өөрөө тогтооно гэсэн ийм зүйл байгаа  
шүү. Энэ хасагдаж байгаа юм.

Би энэ юм тайлбарлаж байгаад.  
Уучлаарай. Горимын санал гаргаад энэ  
саналыг хүчингүй болгох санал хураалт  
явуулья. Санал хураалт. /алх цохив/

Саяын санал хүчингүй боллоо.  
60.0 хувийн саналаар.

Эргээд түрүүчийн томьёоллоороо  
санал хураалт явуулья. Санал хураалт.  
/алх цохив/

10-aас 6, 60.0 хувиар энэ санал  
дэмжигдэж байна.

Төслийн 51 дүгээр зүйл дээр  
асуулт, саналтай гишүүн алга байна. /алх  
цохив/

52 дугаар зүйл дээр асуулт,  
саналтай гишүүн алга байна. /алх цохив/

53 дугаар зүйл дээр асуулт,  
саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын тухай  
хуулийн шинэчилсэн найруулгын  
төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Одоо найруулгын санал байгаа. Би  
уншиж танилцуульяа.

**1. Төслийн 25 дугаар зүйлийн 25.9**  
дэх хэсгийн “ба” гэсний дараа “түүнээс”  
гэж, 24 дүгээр зүйлийн 24.9, 24.10 дахь  
хэсэг, 28 дугаар зүйлийн 28.7 дахь  
хэсгийн “зардлыг” гэсний өмнө “үйл  
ажиллагааны” гэж тус тус нэмж, 28  
дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн  
“зардлыг санхүүжүүлнэ.” гэснийг “үйл  
ажиллагааны зардлыг зориулалтын дагуу  
зарцуулна.” гэж, 30 дугаар зүйлийн 30.2  
дахь хэсгийн “зааснаас” гэснийг “заасны  
дагуу томилогдсоноос” гэж, 35 дугаар  
зүйлийн 35.5 дахь хэсгийн “хууль  
тогтоомжийн” гэснийг “хуулийн” гэж, 36  
дугаар зүйлийн 36.4 дэх хэсгийн “Энэ  
зүйлд” гэснийг “Энэ хуулийн 36 дугаар  
зүйлд” гэж, 44 дүгээр зүйлийн 44.4.1.6  
дахь заалтын “кампанит ажилд” гэснийг  
“сурталчилгаанд” гэж, 46 дугаар зүйлийн  
46.5.17 дахь заалтын “мэдээллийн сан  
бүрдүүлж гишүүдэд үйлчлэх” гэснийг  
“мэдээллийн сан бүрдүүлэх” гэж тус тус  
өөрчлөх.

**2. Төслийн 27 дугаар зүйлийн 27.4**  
дэх хэсгийн “тогтоох асуудлыг” гэснийг  
хасах.

3. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын болон тэдгээрт авсан эшлэлийн дугаарлалтыг өөрчлөх, агуулга, зарчмыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

6 гишүүн дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

Одоо Их Хурлын тухай хуулийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн асуудлыг хэлцэж эхэлье.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай асуудал байгаа.

Улсын Их Хурлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

1 дүгээр зүйл дээр нь асуулт, саналтай гишүүн байна уу?

Ажлын хэсгээс ажлын хэсгээс ирсэн санал байна.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “тус тус өөрчилсүгэй.” гэсний өмнө “. 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24<sup>6</sup>.2-т” гэснийг “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 52.2-т”” гэж нэмэх.

Ажлын хэсгээс гаргасан саналыг дэмжье.

Хэн үлдчихэв? М.Оюунчимэг гишүүн горимын санал гаргачих. Тийм.

**М.Оюунчимэг:** Саяын санал хураалтыг дахин явуулж өгөхийг хүсье.

Би сая кнопоо дарсан боловч сөрөг гарчихлаа.

**Н.Энхболд:** М.Оюунчимэг гишүүний горимын саналаар санал хураалтын дүнг хүчингүй болгох санал хураалт явуулъя. /алх цохив/

Түрүүчийн томьёоллоор санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. /алх цохив/

6 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

